



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/187

Есөнбулаг

“Говь-Алтай 80+” Эрүүл мэндийн  
хөтөлбөрийн хүрээнд урьдчилан  
сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн зорилт 2, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.2.2, 7.2.3 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зудын эрсдэлтэй нөхцөлд байгаа сумдын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 30-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.


2. Нэгдсэн сургалт, ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж ажиллахыг ажлын хэсэг (Т.Мөнхбат)-т, сургалт сурталчилгаа явуулах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах баг бүрэлдэхүүн, эмч, мэргэжилтнийг томилж ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар, шатахууны зардлыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

4. Шаардагдах 3.214.000 (гурван сая хоёр зуун арван дөрвөн мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Мөнхжаргал), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын *2.02.14* оны  
03 дугаар сарын *11* нь өдрийн *18* дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**"ГОВЬ-АЛТАЙ 80+" ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч :	Т.Мөнхбат	(Аймгийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч, хүүхдийн их эмч)
Гишүүдэд:	Д.Сугар	(Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)
	Д.Батчимэг	(Нэгдсэн эмнэлгийн дотрын их эмч)
	Д.Тунгалаг	(Нэгдсэн эмнэлгийн дүрс оншилгооны их эмч)
	Г.Алзахгүй	(Нэгдсэн эмнэлгийн Гэмтэл, мэс заслын эмч)
	Ц.Ариунтунгалаг	(Ариун тун эмийн сан) (Сумдын Засаг дарга) (Сумдын Эрүүл мэндийн төвийн дарга)
	Б.Бямбасүрэн	(Жолооч)

\_\_оОо\_\_

03 дугаар сарын 11-ны өдрийн 187 дугаар  
Аймгийн Засаг даргын 034 оны  
захирамжийн хоёрдугаар хавсралт

“ГОВЬ-АЛТАЙ 80+” ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

1 дүгээр ээлж

- 03 дугаар сарын 11-нд Дэлгэр сум
- 03 дугаар сарын 12-нд Бигэр сум
- 03 дугаар сарын 13-нд Чандмань сум
- 03 дугаар сарын 14-нд Эрдэнэ сум
- 03 дугаар сарын 15-нд Баянтоорой тосгон
- 03 дугаар сарын 16-нд Цогт сум,
- 03 дугаар сарын 17-нд Цээл сум
- 03 дугаар сарын 18-нд Алтай сум
- 03 дугаар сарын 20-нд Бугат сум
- 03 дугаар сарын 21-нд Төгрөг сум

2 дугаар ээлж

- 03 дугаар сарын 22-нд Тонхил сум
- 03 дугаар сарын 23-нд Дарви сум
- 03 дугаар сарын 24-нд Хөхморьт сум
- 03 дугаар сарын 25-нд Баян-Уул сум
- 03 дугаар сарын 26-нд Жаргалан сум
- 03 дугаар сарын 27-нд Тайшир сум
- 03 дугаар сарын 28-нд Шарга сум,
- 03 дугаар сарын 29-нд Халиун сум

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 14 -ны өдрийн 18 дугаар  
захирамжийн гуравдугаар хэвсрэлт

**"ГОВЬ-АЛТАЙ 80+" ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨРИЙН  
ХҮРЭЭНД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Зардлын үзүүлэлт	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Тоо ширхэг	Нийт зардал (төгрөгөөр)
Нэг. Аймгийн ЗДТГ-ын хариуцах зардал				
1.	Сургалтын хэрэглэгдэхүүн, баннер, бичиг хэргийн зардал			100.000 төг
2.	Үзлэгийн шатахууны зардал /3500 км зам, 1 машин, АИ92-бензин/	2780 төг	1120 л х 1 машин	3.114.000 төг
Нийт				3.214.000

\_\_оОо\_\_